

Эрхлэн гаргагчийн үг

Социализмын үед баячууд хөрөнгөтнүүд муу нэртэй, ард түмнийг дарлан мөлжигч гэгдэж байсан. Одоо ч тиймэрхүү ойлголттой хүн цөөнгүй. Үнэн хэрэг дээрээ баян чинээлэг хүмүүс нийгмийг хөгжүүлж, урагш нь авч явдаг жамтай. Тэдний хөрөнгө чинээ их байх тусмаа хөдөлмөр зүтгэлийг нь илтгэн харуулдаг.

Хэн бага хөдөлмөрлөнө, тэр ядуу байдаг. Ядуучууд ихтэй улс орон дорой буурай л байдаг. Харин иргэд баян бол улс баян гэсэн шууд хамаарал буй.

Баячууд хүн ардын хэрэгцээнд тохирсон шинэ бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргаж, барилга, зам гүүрийг бүтээн босгож, бүх төрлийн үйлчилгээг үзүүлж, хөдөлмөрийн байрууд бий болгож, татварт өгдөг мөнгөөрөө эмнэлэг, боловсрол, нийгмийн халамжийг ивээн тэтгэж байна. Ингээд аваад үзэхэд баячуудын нийгэмд гүйцэтгэдэг үүрэг асар их билээ. хөрөнгө капитал, түүнийг голлон буй болгодог бизнесменүүдгүйгээр улс орны хөгжил, ард түмний сайн сайхан амьдралыг төсөөлөхөд хэцүү юм.

Хамгийн гол нь, баячууд гэдэг маань ямар нэг тусгай, гадны хүмүүс биш. Хичээж зүтгэвэл хэн ч хөдөлмөрийнхөө өгөөмөр үр шимийг хүртэж тансаг жаргалтай амьдрах боломжтой. Хүн бүр хөрөнгөтэй чинээлэг аж төрөх эрхтэй. Үүрэгтэй ч гэж болно. Баячууд гэдэг бол нэг ёсондоо ирээдүйн бид бүхэн гэсэн үг. Баяжих нь бид бүхний зорилго, мөрөөдөл тэмцэл.

Олон эх орон нэгтэн маань өнөөдөр өмч хөрөнгөтэй болж, барууны хөгжилтэй гэх улсуудын иргэдээс дутах юмгүй түвшинд хүрсэн байна. Энэ боломж бүгдэд бий. Монгол орон маань хэн бүхэнд хишиг буянаас харамгүй хайрлаж, аз жаргал бэлэглэж чадна. Гагцхүү Монголынхоо ариун хишиг буянаас татгалзахгүй л байх хэрэгтэй.

Баян байх гэдэг урьдын үзэл сурталд нуруулагчидан муу муухай юм биш. Ариун цагаан хөдөлмөр зүтгэл, оюун ухааны зайлшгүй, шударга үр шим юм. Баян байх гэдэг бахархал, нэр төрийн хэрэг билээ. Монгол хүн бүр хувийн аж ахуйтан, өмч хөрөнгөтөн бийсэн гэдгийг санаарай. Баян чинээлэг байх нь манай үндэсний нэг уламжлал юм шүү. Аз жаргалд хүрэхийн тулд баян чинээлэг байхуйн шатыг заавал дамжиж өнгөрдөг. Өмсөх хувцасгүй, идэх хоолгүй ч жаргалтай байж болно гэхчилэн ярьдаг нь тийм ч үнэн үг биш ээ. Үүнийг хүн бүхэн ойлгож байгаа. Тиймээс ч энэ номын хуудсуудыг сөхөн үзэгтэн. Хүмүүс аз жаргалдаа хүрэхийн тулд хэрхэн замнаж, тэмцэж, ялж байсан тухай энэ номд өгүүлнэ. Ядуу хоосон байснаа, яаж хөлгүй баян болсон тухай үлгэр шиг хэдий ч, үнэн түүхүүд таныг хүлээж байна. 20 насандаа үхлийн аюулт эмгэг туссан Рокфеллер ажиллаж тэмцээр, өвчнөө ч мартаж, 90 насалсан. Генри Форд зохион бүтээх авьяас чадвараа сая саяын хөрөнгө болгосон. Билл Гейтс компьютерийн хоббигоо бизнестэй холбож, дэлхийн тэргүүн баян болсон.

Гэтэл онцгой авьяас чадваргүй ч, хүсэл тэмүүлэл байсан учраас зорьсондоо хүрэгсэд ч буй. Тэд нар салхины энергийг ашиглаж, матар юм уу дун хорхой үржүүлж, хог новшийг дахин боловсруулж, хонины аж ахуй эрхэлж, түг түмэн аргаар баяжсан байна. 60 өгүүлэл. Энд бэлгэдэл болсон том баячуудын намтарч бий. Дунд зэргийн хөрөнгөтэй болсон бизнесмений замнал ч буй. Зарим өгүүлэлд адил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг хэсэг хүмүүсийг нэгтгэн харуулсан. Заримд нь буруу замаар будаа тээвэл юу болдог тухай ч өгүүлсэн.

Та бүхэн энэ номсыг уншаад урам зориг орж, эрч хүч авах нь дамжиггүй. Мөн хэн нэгний нь намтар шууд үлгэр дууриал, туршлага сургамж ч болно.

Хувь заяаныхаа жолоог гартаа атгаж, залан чиглүүлж чадсан бизнесмен хүмүүсийн тухай нэгэн номыг сэтгүүлч Ч.Мөнхбаярт захиалж бичүүлсэн минь энэ билээ. Уг ном зохиогчийн чанартай болсон тул тэргүүнд сэтгүүлчийн нэрийг тавьж хэвлүүллээ.

Урьд өмнө нь "Өлсөхүйн гайхамшиг" (Пол Брэгг), "Монгол домын гайхамшиг" (Ч.Мөнхбаяр, Н.Батжаргал) номууд гарсныг уншигчид санаж байгаа байх. Энэ "Дэлхийн баячуудын гайхамшиг" ном миний эрхлэн гаргаж буй гайхамшигийн тухай цуврал номуудыг үргэлжлэл юм. Удалгүй "Инээхүйн гайхамшиг" номыг уншигч таны гар дээр тавихаар зэхэж байна.

Эцэст нь хэлэхэд, та бүхэндээ баяжигтун гэж уриалахыг хүсч байна. Хүсэл мөрөөдлөө биелүүлж аз жаргалд хүрэх үүд хаалгыг өмч хөрөнгө нээж өгөх билээ. Баян чинээлэг болох авьяас чадвар хүн бүхэнд бий юм шүү. Гагцхүү тэр авьяасаа илрүүлэн олж, хөгжүүлэн дэвжээж, баяжигтун!

Номыг эрхлэн гаргагч Н.Батжаргал

АГА ХАН

Баяжихыг номлодог шашны ачаар...

Олон зууны тэртээ Махди Аме гэдэг араб эр лалын шашны исмаилит хэмээх урсгалыг үндэслэжээ. Уг шашин баяжихыг уриалдаг бөгөөд даган бишрэгчид нь толгойлогчдоо байнга алт эрдэнэс бэлэглэж байх учиртай. Хаана баяжих боломжтойв, түүнийг эх орноо хэмээ гэж сургадаг тул исмаилитууд сайн дураараа даян дэлхийгээр нэг тарсан юм. 20 сая исмаилитууд ерөнхийдөө чинээлэг хүмүүс агаад насанд хүрэгч дөрвөн хүний нэг нь баян худалдаачин байдаг. Ийм өвөрмөц "хаант улсын" эзэн байх гэгч нь хамгийн тааламжтай хувь тавилан мэт.

Исмаилитуудын дээд имам нь Амегийн л удам байх ёстой. Хэрэв Амегийн удам болж төрсөн бол баяжихаас өөр юу ч хийхгүй байхад болно. 1957 онд IY Ага Ханы хүзүүнд 3 кг жинтэй, эртний хийцийн, дээд имамын зүүлтийг зүүж өгчээ. Голливудын жүжигчдийн дунд цэнгэхээс өөрийг мэдэхгүй энэ залуу ийнхүү исмаилитуудын тэргүүн болов. Имам Танзаний Дар эс Салам дахь исмаилитын ариун өргөөнд суух учиртай авач, IY Ага Хан уг ордонг яг тэр загвараар нь Лондонд бариулаад аж төрөв. Аж төрөв ч гэж, тэр Лондонд бараг ирдэггүй бөгөөд америкийн хамаг сайхан хүүхнүүдийг тэврэхэд л амьдралаа зориулдаг. Зөвхөн зугаа цэнгэл хөөцөлдөж байхад нь, түүнийг гэгээн хэмээн бишрэгч исмаилитууд Энэтхэг, Пакистан, Иран, Сирид борви бохисхийлгүй өөрийнх нь төлөө хөдөлмөрлөж байдаг.

Жил бүр исмаилитууд эзнийгээ эрдэнэсээр жигнэх ёслол үйлдэнэ. Ингэхдээ жинлүүрийн нэг таваг дээр имам заларч, нөгөө тавган дээр жин тэнцтэл эрдэнэс овоолдог байна. 1946 онд II Ага Хан 95 кг жинтэй байсан агаад, 5 сая долларын эрдэнэстэй тэнцжээ. IY Ага Ханыг өөрийнх нь хүссэнээр дээд зэргийн бриллиантаар жигнэдэг болжээ.

Түүнээс гадна исмаилитууд орлогынхоо 10 хувийг имамдаа өргөж байх учиртай юм. Энэхүү үнэнч шавь нар нь хоорондоо нягт уялдаатай хамтран ажиллаж, биесээ ихэд тэтгэх дэмжих тул ажил үйлс нь бүтэлтэй, ашиг орлого нь арвин байдаг. Шашин, улс төр, эдийн засгийн төвлөрсөн удирдлагатай. Эрчимтэй хөгжиж буй нэгэн хаант улс л гэсэн үг. Эсвэл хамгийн олон ажиллагсадтай компани ч гэлтэй.

III Ага хан хамгийн ухаалаг Ага байв. Тэрбээр цэнгэж суухыг гол болголтгүй, эд хөрөнгийг арвижуулдаг байлаа. Энэтхэг, Пакистаны жутын тариалан, нэхмэл сүлжмэлийн салбарт хөрөнгө оруулав. Дэлхийн үүлдэр угсаа сайтай морьдын аж ахуйд тэр ихээхэн үүрэг рольтой асан. Эгэл хүнд бол ийм нэг морь ч бөөн хөрөнгө гэсэн үг. Сардини арал дээр далайн эргээр ихээхэн газар худалдан авч. Хост Смеральдын амралтын цогцолбор байгуулав. Тансаг энэ газар зөвхөн саятнуудад үйлчилдэг бүлгээ.

Гэхдээ түүний бизнес үйл ажиллагааны ихэнх хэсэг нь үнэт цаас руу чиглэдэг байсан. Санд орж ирэх мөнгө хөрөнгөөр хамгийн ашигтай акци худалдаж авах нь Ага ханы нэг хобби. Акци худалдааны талбарт бизнесийн том том мангасуудтай үзэлцэж, ялж гарах нь зүйрлэшгүй таашаалыг авчирна. Өрсөлдөгчид нь болгоомжтой, буулт хиймтгий байхад манай хүнд ямар ч эрсдэл аюултай биш. Хэмжээгүй эрхт хаан болохоор юунаас ч эмээх билээ дээ. Швейцарийн банкуудад хадгалагдаж байдаг үнэт цаас нь Ага Ханыг маш бие даасан хүн болгосон. Исмаилитууд түүнээс нүүр бурууллаа ч, санаа зовох юмгүй болсон. Гэхдээ энэ овсгоотой хүн юу гэж шавь нараасаа хөндийрөх вэ дээ.

Улс төр түүний ашиг сонирхолд үйлчилсэн. Мань эр англичуудтай эв найртай байж, хамтран ажиллахыг исмаилитуудад байнга уриалж байв. Ялангуяа энэтхэгийн шавь нартаа чухалчлан ятгана. Үүний үрээр, англичууд исмаилитуудыг тал бүрээр дэмжин тэтгэж, ашиг орлогыг нь нэмэгдүүлж байлаа. Түүнээс гадна, Ага ханыг тусгайлан ивээнэ.

Мөн исламын том зүтгэлтний нэр нөлөөгөө ашиглаж, няйт лалынханд Британи бол авран хамгаалагч, итгэлтэй анд хэмээн сурталчилж асан. Энэ нь Британий Энэтхэг дэх колоничлолыг бэхжүүлэхэд хөөрхөн дэм болно. Манай хүн ч үзүүлсэн тусаа олон дахин нугалсан хариуг нэхэхээ мартаггүй.

Түүний ислам хөзрөөр наадсан нь ямагт санхүүгийн ашгийн төлөө байсан юм. Пакистан улсыг бий болгох үйлсийг Ш Ага Хан далайцтай гэгч дэмжиж байв. Тэр нь түүнд ямар нэг ард түмний талаар бус, асар ирээдүйтэй компаний тухай асуудал мэт төсөөлөгдсөн нь үнэнтэй. Британий Энэтхэгийн мусульманчуудыг урьд нь хэзээ ч байгаагүй Пакистан улс болгож зохион байгуулах утопи мэт үзэлтнүүдийн тэргүүн эгнээнд Ага явдаг асан. Энэ асуудлаархи төлөөлөгчдийг нэг бус удаа тэргүүлэн англичуудтай хэлэлцсэн.

Тэдний зорилго бүрэн биелээгүй. Зүй нь одгөө Пакистаны хүн ам 300 илүү сая байх учиртай. Гэвч Дорнод Пакистан салан тусгаарлаж, Бангладеш улс болсон ба Энэтхэг улсад үлдсэн мусульманчуудтай нийлээд 200 гаруй сая ислам хүн зорилгоос гадуур үлджээ. Зөвхөн шашны үндсэн дээр улс байгуулна гэсэн хийсвэр санаа иймд хүргэсэн аж. Пакистан улсад ч эв нэгдэл үгүй бөгөөд хэн хэнээсээ давамгайлалгүй пенжаб, пуштун, синдх, сарайк, белуж, брагуи, мухажирчуудаас хүн ам бүрдэнэ. Энэ нь ард түмний тухай бус, ашгийн тухай л бодож явсан Агад юуны нь ч хамаа байх вэ дээ. Шинээр буй болсон Пакистан улс Ага ханыг зүйл бүрээр харж үзэж, арвижуулж баяжуулсан нь л үнэн юм даг.

Исмаилитын зарим том мяндагтан та юунд ингэж бизнес хөөж, биеэ зовооно вэ, бидний өргөл хангалттай бус уу гэхэд Ага хан "Бизнес хийх гэдэг чинь муу үйл биш шүү дээ. Хөдөлмөр, буяны л нэг хэлбэр. Хүн бүхэн бизнес хийх ёстой гэж би боддог. Өөрөө гар хумхин суучихаад шавь нарыгаа мөнгө ол гэж хэрхэн шаардах билээ. Харин ч та нарынхаа өргөсөн буянг арвижуулах нь миний үүрэг" гэдэг байв.

Буяны тухай өгүүлэх атлаа Ага хар тамхины наймаанд багагүй орооцолдсон. Афганистан, Пакистан, Ираны опиум-бизнесд их үүрэг гүйцэтгэсэн юм. Гэхдээ исмаилитууд опиумыг нэг их хилэнцтэй зүйл гэж үздэггүй. Анхны хувилгаан багш нар нь хар тамхины тусламжтайгаар номлолоо дэлгэрүүлж байсан. Бүр дундад зуунд исмаилитууд жинхэнэ олон улсын наркомафи байсан бөгөөд баялгийн эх сурвалж нь чингэж тавигдсан. Мафийн Сири дэх голомтыг түркүүд, Персийн голомтыг монголчууд устгаснаар тэд хар тамхи наймаалахаа больсон түүхтэй.

Ш Ага хан зөвхөн бизнес хөөсөн нэгэн байгаагүй. Урт удаан насалсан энэ эзэн Ривьерээс Флорид хүртэлх өргөн уудам нутагт хаана л баячууд хөлөг уралдуулж, ан хийж, цэнгүүн зохиож, шампан залгилнав, тэдэнд амжиж очно. Персийн хааны гүнж, Монте Карлогийн бүжигчин Тереза Мальяно, Ниццагийн дагина Ванесса Карлон, "Мисс Франц" Иветта Лябрус, дорны гуа бүсгүй Бегума Халид гээд л үзэсгэлэнт бүхэнтэй гэрлэж амжсан. 1957 онд Ш Ага нас барж, Египетэд түүнийг оршуулахдаа энэ орны нэг бахдам гайхамшиг болсон бунханг босгожээ.

Ямар ч эх оронгүй авч, хамгийн баян хаант улсын эзэн Ага хануудын үлгэр домог мэт амьдрал үргэлжилсээр байна.

ИСААК АЗИМОВ

Уран зөгнөлийн хаан

Дэлхийн хамгийн мэдлэгтэй хүний тоонд орох Исаак Азимов саятан билээ. Гэхдээ түүнийг бизнесмен гэж нэрлэвэл бүдүүлэг хэрэг болно. Тэрбээр 40 жилийн турш америкийн зөгнөлт уран зохиолд ноёлсон.

Түүнээс гадна шинжлэх ухааны хялбаршуулсан бүтээлийн хаан. 1990 оны 1 дүгээр сарын 2-нд 70 нас хүрэхдээ 445 ном бичиж, редакторлаж нийтлүүлсэн, 20 гаруй ном нь хэвлэлд бэлтгэгдэж байв. Азимовын ядаж ганц номны сэдэв болоогүй мэдлэгийн салбар ховор. Физик, одон орон, геологи, газарзүй, биологи, математик, түүх, кибернетик, мэдээллийн технологи, зөв хооллох ухаан, уран зохиол, библи судлал зэрэг шинжлэх ухааныг тэр сайн мэддэг билээ. Мөн хошин шог, шүлгийн ном гаргасан. 1600 хуудас, хоёр ботьтой намтраа хэвлүүлсэн.

Зарим нь Азимов 110 номыг бичээгүй, редакторласан шүү дээ гэдэг. Гэвч ажлыг хийсэн шиг хийдэг Азимов маш чамбай редакторладаг нь ач холбогдлоор хэн нэгний ном бичдэгтэй тэнцэнэ. Тэгээд ч 335-ыг бол цэвэр өөрөө туурвисан байлаа.

Азимовын номууд бүхэл бүтэн номын сан болно. 84 хэлээр орчуулагдаж гарсан. Нэг ном нь дунджаар 11 удаа хэвлэгдсэн. Ном болохоосоо өмнө хэсэг хэсгээрээ сонин сэтгүүл дээр гараад амжчихдаг. Түүний зохиолыг уран сайхны, баримтат кинонд ашиглаж, түүвэрт оруулж, элдэв арга хэмжээ, рекламанд хэрэглэсэн нь цөөнгүй. Редакторласан номноосоо ашгийн жинтэй хувийг авдаг. Азимов гэсэн нэртэй номонд сурталчилгаа их ирдэг. Тэр янз бүрийн шагнал авсан нь тоолж баршгүй. Энэ бүхний дүнд Исаак дэлхийн хамгийн баян зохиолчдын нэг болжээ.

Хийдэг цорын ганц ажил нь бичих. Хэдий завандаа уншиж, нэвтэрхий толь мэт болсон хэрэг вэ гэж уншигч гайхаж магад. Хэргийн учир гэвэл тэр бичихдээ уншиж, уншихдаа бичдэг.

Асар хурдан туурвидаг нь түүний атаархам онцлог. "Сатердей ивнинг пост" сэтгүүл өгүүллэг хүсээд тэр дороо 1600 үг авахдаа, бэлэн юм байсан биз гэж таамаглажээ. Гэвч зохиолч хоёр цагийн дотор цоо шинэ өгүүллэг бичсэн байв.

Исаакийн хувьд мөнгө хөөсөндөө ч юм уу, нүд хуурч ажиллана гэж байдаггүй. Бичих дуртай, бичих бол аз жаргал гэж боддог, тэгээд л гүйцээ. Бичнэ гэдэг түүний ажил, амралт, хобби. Хааяа нэг зугаагаа гаргах гэж унших бөгөөд, тэгэхдээ зөвхөн детектив барьж авдаг, харин уран зөгнөлийг сонгодоггүй гэнэ. Мань хүн өөрөө ч цөөнгүй детектив бичсэн. Детектив бол зохиолч, уншигчийн аль алины хувьд сэтгэлгээний гимнастик болно гэж хэлсэн удаа бий.

Өглөөний 7 цагт ширээний ард суугаад, унтгалаа бараг хөндийрдөггүй. Гэрээс төдийлөн гардаггүй, Нью-Йоркоос өөр газар очиж үзээгүй гэхэд хилсдэхгүй. Цаасан дээр бичилгүй удсан тэр хэвлэх газар луу номоо компьютерээсээ л илгээдэг. Ажилд нь саад учрах вий гэж маш их айна. Тиймээс нэг зүйл эвдрэх юм уу, болохоо байлаа гэхэд хэрэглэх нүсэр нөөцийг бэлэн байлгадаг.

Сансар огторгуйн тухайн их бичсэн тэр өндрөөс, орон зайнаас айдаг. 33-р давхарт байдаг сууцныхаа тагтан дээр огт гардаггүй. Тэгсэн атлаа өөр газар нүүж очьё гэх нь юу л бол. Ахуйн аливаа өөрчлөлтийг дурамжхан хүлээж авдаг.

Хуралд оролц, шагнал, эрдмийн зэргээ ав гэсэн урилгууд татгалзсан хариугаар төгсдөг. Учир нь гэрээсээ 1 хоногоос илүү хугацаагаар явахгүй гэсэн хуультай. Мөн автомашинаас өөр унаанд суухгүй гэдэг. Энэ нь орон зайнаас айдгаас үүдсэн гэнэ.

Супер зохиолчийн статус Азимовыг гаж араншинтай болгосон ч, ширээнийхээ ард л сууж байвал тэр хамгийн аз жаргалтай байдаг ажээ.

Исаак Азимов зөвлөлтийн зохиолч байж болох л байсан. Смоленскоос 90 км хол орших Петровичи хотхонд төрсөн нь үнэн билээ. Америк руу яваагүй бол 445 байтугай, 40 ном хэвлүүлж чадахгүй байсан. Зөвлөлтөд 10 номоо хэвлүүлбэл дээдийн заяа гэгдэнэ. Бас шинжлэх ухааны уран зөгнөлийг үзэл сурталчид ойшоодоггүй байв. Тэгэхлээр Азимов гэдэг нэр дэлхий даяар алдарших байсан уу, үгүй юу.

Исаакийн авга ах Нью-Йоркийн Бруклинд дажгүй төвхнөөд дүүгийнхээ гэр бүлийг цагаачлан ир гэж дууджээ. Энэ нь осолтой хэрэг байв. Аягүйдвэл социалист эх орноосоо урвалаа гэж яллагдаж ч мэднэ. Удаан эргэлзсэний эцэст явах шийдвэр гаргахад Исаак 3 настай байжээ.

Нагацын зээллэгээр тэднийнх чихрийн дэлгүүр нээсэн нь хэвлэлийн мухлагтай байлаа. Тэндээс сонин сэтгүүл авч сонирхох гэхэд аав нь хүмүүжилд муугаар нөлөөлнө хэмээн хатуу хориглож, зөвхөн хичээлээ давтаж, танин мэдэхүйн ном уншихыг л шаардана. Хожим шинжлэх ухааны сэтгүүлийг мөн зөвшөөрчээ. Эцгийн цензур хүүгийн оюун

ухааны хөгжилд нөлөөлсөн нь лавтай. Исаак өдгөө ч телевиз, сонинд огт анхаарал хандуулдаггүй бөгөөд зөвхөн эрдмийн сэтгүүлээр хэвлэл мэдээллийг төлөөлгөдөг.

18—тай, Колүмбийн их сургуульд сурч ахуйдаа анхны өгүүллэгээ нийтлүүлжээ. Биохимээр мэргэжиж, Бостоны их сургуулийн багш болов. Докторын диссертаци хамгааллаа. Уран зөгнөлд зугаа гаргах маягаар хандаж байв. Гэтэл өөрийн уншигч фэнүүдтэй болсныгоо мэдээд алмайран гайхлаа. Тэдний олон тооны хүсэлт номоо гаргах бодлыг төрүүлжээ. 1950 онд хоёр боть зөгнөлөө хэвлүүлж, яггүй амжилт олов. Эрдэмтэн болно, нээлт хийнэ гэсэн эрмэлзэл Исаакийг 1958 он хүртэл лабораториос салгаагүй нь харамсалтай ч юм шиг. Химийн судалгаанд их цаг хүчээ зарсан ч санасан үр дүнд хүрсэнгүй. Улам бүр сэтгэлийг эзэмдэн буй уран зөгнөлд орьё гэж хатуу шийдэж, эртхэн ингэх минь яав хэмээн харамссан мөч нэгэн сайхан нартай өдөр тохиожээ. Азимов зөгнөлт зохиолоор л алдаршсан нэгэн. Анх роботуудыг сайн сайхнаар дүрсэлсэн хүн. Робот, компьютер нийгмийн олон тулгамдсан хурц асуудлыг шийдвэрлэнэ гэж үздэг. Түүний зохиосон роботтехникийн гурван хууль уншигчдын сэтгэлд баттай хоногшсон.

1. Робот хүнд хор хөнөөл учруулах буюу, эсвэл хүнд учрах хор хөнөөлтэй эвлэрэх ёсгүй.

2. Эхний хуультай зөрчилдөхөөс бусад тохиолдолд хүний өгсөн бүх тушаалыг биелүүлнэ.

3. Эхний болон хоёрдахь хуультай зөрчилдөхөөс бусад тохиолдолд робот өөрийгөө хамгаалах эрхтэй.

1942 онд нэгэн өгүүллэгтээ санал болгосон энэ хуулиудыг уран зөгнөлийн бүх зохиолчид хүлээн зөвшөөрчээ. Энэ л хуулиудад захирагдах роботуудыг хийх учиртай гэдэг нь термодинамикийн хуулиуд шиг л хөдөлшгүй үнэн болсон юм.

1941 онд 6 ботит Үндэс романаа эхэлжээ. Галактикийн хоёрдахь гүрний зохиолч анхны гүрний тухай бичиж буй маягаар бүтээсэн. Эхний 3 боть 1953 онд гарч дууссан. Гэтэл 30 жилийн дараа, 1983 оноос эхлэн ахин 3 боть бичиж хэвлүүлсэн юм. Үүнийгээ үргэлжлүүлэхгүй гэсэн тул Даблдэй хэвлэлийн газар зохих эрхийг Азимовоос худалдан аваад, өөр зохиолчоор дараагийн ботиудыг бичүүлж буй гэнэ.

Шинжлэх ухааны уран зөгнөлийн хаан. Энэ бол Азимовын нэг л цол юм. Тэр бас шинжлэх ухааны хялбаршуулсан бүтээлийн хаан билээ. 1957 онд ЗХУ хиймэл дагуул хөөргөснөөс хойш Америкийн засгийн газар аливаа эрдэм мэдлэг дэлгэрэхийг ихэд хөхиүлэн дэмжиж, хүмүүс ч урам зоригтойгоор эзэмшиж байсан. Чингэхэд хялбаршуулмал зохиол амжилтолно гэждүгнээд, Азимов шинэ жанр луу ажил хэрэгчээр дайрав. Жилд хорь гучин хялбаршуулмал ном бичиж байсан ч удаатай.

1973 онд тэрбээр өөрийг нь бишрэн шүтэгч эмэгтэй Жанеттэй гэрлэсэн. Жанет Жеппсон мен зөгнөлт зохиолч бөгөөд хүүхдүүдэд зориулан бичдэг. 14 ном нь амжилт олсон. Авааль ханийн хувьд нөхрийнхөө бүтээл туурвилд тааламжтай бүх нөхцөлийг бүрдүүлж өгдөг.

70 насныхаа ойг даруухан тэмдэглэхдээ Азимов:

-Эцэг эх маань 70 гараад өөд болсон. Тэгэхлээр миний амьдралын сүүлчийн жилүүд эхлэв бололтой. Үүнийг ухамсарласны дүнд ажил хэрэгч байдлаа нэмэгдүүлж чадна гэж бодож байна. Би ер нь сэтгэлдээ хүрэх хэмжээнд хэзээ ч ажиллаж байгаагүй гэжээ.

АМИН, МАСИАС, БОКАССА

Улсаа хувийн өмч болгосон дарангуйлагчид

Далаад онд ТАБНУ, Уганда, Экваторын Гвиней улсуудад Бокасса, Амин, Масиас гэж гурван дарангуйлагч гарч ирсэн билээ. Бокасса хууль ёсны ерөнхийлөгч, өөрийн хамаатан Давид Даког түлхэн унагасан. Амин танкны хүчээр замаа шулуутгасан. М иасиасыг испаничууд ерөнхийлөгч болгоод явсан.

Энэ гурван хүн дорхиноо дэлхийн баячуудын эгнээнд багтсан билээ. Бокасса ТАБНУ-ын үндэсний бүх баялгийг өөрийн хувийн өмч гэж тооцсон. Амин Угандын эдийн засгийг балгас мэт болгосон. Масиас улсын санг өөрийн касс гэж үзсэн. Ингэж байж гурвуул үлгэрт гардаг шиг дороо баяжсан билээ.

Амин францын Фигаро сонинд өчихдөө "Улсыг захирах нь хувийн компанийг удирдахтай адил. Компаний төлөө зүтгэснийхээ төлөө хөрөнгийг нь дураар зарцуулах эрх надад буй" гэжээ.

Бокасса Францын, Амин Английн, Масиас Испанийн армид офп цер байв. Эдгээр улсууд нь гурвууланг нь дэмжиж тэтгэж байлаа. Дэмжихийн сацуу, бид л удирдахгүй бол африкчууд ийм л болж байгаа юм даа гэж сурталчилдаг байсан.

Масиас 45 албан ёсны өргөмжлөлтэй байв. Улсын нэгэн тугээмэл лоозон нь "Масиасын төлөө Бурхан Экваторын Гвинеийг бүтээсэн юм" хэмээнэ. Амин насан туршийн ерөнхийлөгч, фельдмаршал, олон улсын эрхийн доктор, Британий эзэнт улсыг ялан дийлэгч гэгдсэн. Бокасса улсаа үе залгамжлах хаант улс болгон тунхагласан билээ. Амин Масиас хоёр Гитлерийг, Бокасса Наполеоныг биширдэг байв.

Угандын дарангуйлагч Иди Амин уг нь хөгжилтэй нэгэн офицер байжээ. Тэр хаана л байна, тэнд инээд баясал үүсдэг байжээ. Гэхдээ мань хүнийх ошигнол хэнийгч гомдоохооргүй эвлэгхэн. Бас Амин бор дарс яггүй хүртчихнэ. Энэ нь түүнийг бүх хүнтэй найз нөхөр болгожээ. Хамаг мөнгөө хүн дайлаад л үрчихнэ. Зарим нь, анэ гэмгүй сайн хүнийг архи л баллана гэлцэж, архичин болно доо, хөөрхий гээд гуниг царайлна.

Аажимдаа тэр харьцах хүнийхээ хүрээг хумьжээ. Өөрийнх нь цэцэрхлийг бишрэгч офицеруудтай л архидах болж. Гэхдээ ямагт л ялихгүй байдлаа ялан дийлж, хувьсгал хийж хэн болохоо харуулна гэж ярина. Түүнийг хөндлөнгийн хүмүүс архины цагаан солио туссан хэмээн таамаглаж, төдийлөн үл ойшооно.

1971 оны нэгэн өдөр Амин хамсаатан офицеруудынхаа чамтаар төрийн эргэлт хийж, ерөнхийлөгч Оботег унагажээ. Өөрийн алия марзан, архичин согтуу багийг хуу татан хаялаа. Тэрбээр харгис хэрцгий, хязгааргүй шуналтай нэгэн байжээ,

Өөрийнх ньдургүйг хүргэж байсан 500 гаруй хүний нэрсийн аль эрт бэлдчихсэн жагсаалтыг гаргаж ирээд, оботеистууд хэмээн цаазаар авав. Одоо л нэг Угандад тайван амьдарч болох боллоо гэж тэр ярьжээ. Хамгийн үнэнч фенүүдийгээ өндөр албан тушаалд тавьж байсан бөгөөд тэдний олонх нь бичиг үсэггүй байв. Гагцхүү улсын эд баялгийг тонохыг л тэд мэднэ.

Гэхдээ Аминыг хэрхэн гүйцэх билээ. Хурандаа цолоос фельдмаршал руу дэвшихэд хоёрхон цагийг зарцуулсан тэрбээр эдийн засаг, нийгмийн бүх салбарыг удирдах онцгой эрхийг өөртөө олгосон. Оюуны "хөрөнгө оруулалтынхаа" төлөө тэр улсын орлогын тавин хувиар шагнуулах эрхтэй гэсэн хууль гаргав. Угтавин хувь нь зуун хувь болж өссөнийг таахад түвэггүй.

Хөвөн, кофе,цай, хушга, шар будааны тариаланг Иди Амин үр ашиггүй байна гэсэн нэрийн дор улсын болгов. Тодруулбал, өөрийн хувийн өмч болголоо. Ямар нэг ферм юм уу, үйлдвэрийн эзэн дээр Амины хүмүүс ирээд л "их фельдмаршалд аж ахуй чинь таалагдлаа, тийм учир азтай тавилангаа биширч, өчүүхэн өмчөө аугаа жанжиндаа өргө" гэдэгбайв. Хэрэв үгүй гэвэл оботеист гэгдэн, наад зах нь матар үржүүлгийн газрын амьд хоол болно. *Эси* мэнд үлдэхийг дээд хувь заяа хэмээсэн хөөрхий хүмүүс үй олноороо өмчөөсөө татгалзаж, Идид өргөн барьж байлаа.

Амин дорхиноо дэлхийн 100 баян хүний тоонд оров. "Уганд бол Бурхнаас надад заяасан миний хувийн компани, угандчууд бол манай компаний ажилтнууд" гэж байн байн давтах боллоо. Улсыг компани гэж үзэж удирдах ёстой гэсэн болхидуу "онол" дэвшүүлэв.

Энэ бодолдоо хэт автсан Амин хүн ардыг ямар ч эрхгүй болгосон төдийгүй, өөрийн каква угсаатныг хамгийн аугаа дээд үндэстэн гэж зарлаад, бүгдийг нь "компаний удирдах местүүд" дээр томилов. Каква бус угандчуудыг хэзээ ч удирдах ажил хийж болохгүй боолууд хэмээсэн. Нүүдэлчин карамажонгуудыг мал хариулдаг мал гэж тооцож байв.

Амин зөвхөн харгислалын гусламжаар л дэглэмээ тогтоон барьж байлаа. Үсэг бичиг үл мэдэгч түүний мэргэн ухаанд өчүүхэн төдий эргэлзсэн хэн ч гэсэн аймшигт тарчлалаар төгсөнө. Английн колоний армид байхдаа л тэр хэрцгийгээрээ зард гарч, Боомлогч хоч зүүжээ. 50-иад онд Кенид гарсан бослогыг даралцаж байхдаа Иди олон хүнийг боомилж алсан байна. Хожим тэр утандын ард түмнийг боомилон хамаг шүүсийг нь сорсон.

1979 онд Угандын өмнөд хэсэгт Амины усрэг бослого гарлаа. Тэднийг дор нь дарж, зугтсан босогчдыг мешгих нэрийн дор Танзаний нэлээд нутгийг эзлэн авчээ. Эзэлсэн нутагтаа Амин өөрийн дэглэмийг тогтоож, ард иргэдийг нь харгислан дээрэмдэв. Үүнд эгдүүцсэн Танзаний арми угандын зэвсэгт хүчинд үхлийн цохилт өглөө. Уганд даяар Амины эсрэг бослого өрнөж, манай хүн Англи руу зугаахаас өөр аргагүйд хүрчээ. Лондон дахь тансаг ордондоо ирээд Амин "8 жилийн дотор компаниасаа олж болох бүх ашгийг би авч чадсан. Надад харамсах юм алга. Уганд бол угаасаа явуургүй компани байсан юм. Тэгээд л дампуурлаа" гэжээ. Тэрбээр насан эцэслэлтээ Европод алт алмазан дунд хөлбөрөн жаргасан юм.

1968 онд испаничууд Экваторын Гвинейг орхин одоодоо колоний захиргааны дуулгавартай хичээнгүй албан хаагч Нгема Масиасыг ерөнхийлөгч болгоод явжээ. Масиас эелдэг зөөлөн зангаараа алдартай байв. Гэтэл энэ бяцхан улсын ерөнхийлөгч болонгуутаа дэлхийд зартай дарангуйлагч болчихдог байна шүү.

Өөрийг нь бишрэн шүтээгүй хэн бүхнийг тамлан хороож байв. Онцгой жигшлийг нь төрүүлсэн нэгнийг тэр ордондоо тамлуулах агаад тарчлан зовохыг нь харж таашаал авна. Нгемаг тэргүүн болохоос өмнө Экваторын Гвинейд 300 мянган хүн аж төрж байв. Дарангуйлагч богино хугацаанд 50 мянгыг нь цаазаар авлаа. 100 мянган хүн айдас хүйдэст автан дүрвэжээ. Үлдсэн 150 мянгын 60 мянга нь шоронд сууж байв. Масиасын олон цол хэргэмийг нэрлэхдээ өчүүхэн алдаа гаргахад л улс төрийн хоригдол болоход хангалттай байв. Тэднийг Масиас хувийн боолууд болгон ашиглана.

Масиас мөнхийн хутагт аугаа ерөнхийлөгч, боловсролын гроссмейстер, ертөнцийн гайхамшиг гэхчилэн 45 гуншинтай. Католик сүмүүдэд мөргөлөө "Бурхан Масиаст зориулж Экваторын Гвинейг бүтээсэн юм" гэж эхлэхийг тушаасан. Хожим бүр "Масиасаас өөр Бурхан үгүй" хэмээхийг зарлигдсан.

Ард түмэн Масиаст мөргөж, түүний төлөө л ухамсарт амьдралаа зориулах ёстой гэж албан ёсны үзэл сурталд номлоно. Жил бүр Масиас 25 сая паундын цалин авч байв. Мөн улсын аж ахуйн гол үндэс болсон какао, кофе, бананы тариаланг хувийн өмч оолгожээ.

Масиас улс төрийн хоригдол 60 мянган хүнээс гадна, Рио Муни мужийн 40 мянган оршин суугчийг жинхэнэ боол болгон хувиргажээ. Түүний бодлоор бол, хоёрхон мужтай энэ улсын Фернандо Погийнхон нь болохоор арай дээгүүр хүмүүс, Рио Мунигийнхон доод арьстнууд аж.

Тэдгээр боолчуудад ямар ч эрх байгаагүй бөгөөд чармай

нуцгн ажиллана. Боол эзэмших ёсыг сэргээсэн нь Масиаст асар

их орлого оруулж байв. Сүүлдээ бүр фернандо почуудыг ч олноор

нь боолчлох болжээ. Экваторын Гвиней тэр үед Африкийн

концлагерь хэмээх эрхэм сайхан алдар нэртэй байлаа. Улсынхаа хамаг мөнгийг сороод зогсолгүй, гадаадаас асар их зээл тусламжийг аваад мань хүн халаасалчихна. Төрийн албан хаагчдад цалин өгөхөө байв. Бүх кассууд хов хоосон болов. Харин Гвинейгээ асар том боолын аж ахуй болгон хувиргасан Масиас л баяжсаар. Тансаг ордондоо тэрбээр Европоос урьсан хүүхнүүд болон жүжигчид, хөгжимчидтэй өдөр шөнөгүй наргиж хэвтэнэ.

Экваторчуудын дүрвэх нь улам ихэссэн тул Масиас хөвдөг бүхнийг живүүлжээ. Загасчид авто дугуйны камер үлээж холбоод тэнгист гардаг болов. 1976 онд 100 сэхээтэн улс орноо аврах төлөвлөгөө боловсруулаад түүнд бараалхжээ. Тэднийг олон едрийн турш тарчилган хөнөөсөн байна. 1979 онд ард түмний тэвчээр барагджээ. Тэртэй тэргүй гарцаагүй сүйрэл нүүрлэсэн тул тэд үхэл, тамлалаас айлгүй эрслэн босов. Зальт Масиас өөрийн үеэл дүү Мбасогод тэднийг толгойлохыг даалгав. "Ахынхаа эсрэг ч тэмцэж чадах шударга" Мбасогог боолчууд дэмжлээ. Үеэл дүү болохоор цаагуураа

хамаг баялгаа зөөж гаргахад нь ахдаа тусалж байв. Масиас мөн л үлдсэн насаа Европод цэнгэж өнгөрүүлжээ.

1965 онд Төв Африкийн БНУ-д эргэлт гарч, ерөнхийлөгч Дако амиа алдаж, сууринд нь Францын армид 23 жил зүтгэсэн, францын иргэн Жан Бедель Бокасса заларлаа. Ердөө л маргааш нь үндсэн хуулийг хүчингүй болгож, парламентыг тарааж, бүх намыг хориглов. Улсаа хэмжээгүй эрхт эзэн хаант улс болгон зарлалаа. Алмазын ордууд бол эзэн хааны хувийн өмч гэж мэдэгдэв.

Хаан титмийн ёслолд тэр францын уран дархчуудаар бүтээлгэсэн 2000 бриллианттай титим, 2 тонн алтаар урласан сэнтийг авчруулав. Мөн Европоос 44 люкс мерседес, 6 лимүзин мерседес, дээд зэргийн 22 тн шампан, 150 тн дарс, мөн хамгийн цэвэр үүлдрийн 130 цасан цагаан хөлөг морьд гээд л тоо томшгүй олон тансаг зүйл захиалан ирүүлжээ. Наполеоны хаан суудалд залрах ёслолоос нэг ч зүйл зөрөх ёсгүй, гэхдээ илүү тансаг сүрлэг байж болно гэж Бокасса заавардсан аж.

Титмийн ёслолд 500 сая доллар үрсэн байна. Гэвч Бокасса үүнд санаа зовсонгүй. Очир эрдэнийн асар их баялаг түүний хөмрөг рүү урссаар. Шуналт дарангуйлагч эдийн засгийн бусад салбар луу ч тэмтрүүлээ сунгаж, ээлж дараалан залгиж байлаа. Улс оронд өлсгөлөн болж байхад тэр Европод бас нэгэн цайз худалдан авахаар аялж явдаг. Гадаадын одонгоор шагнуулах донтой үүнийхээ төлөө бусад улсын сайд түшмэдийг хайр найргүй өндөр үнээр хахуульддаг байлаа. Кремлийн алмазын санд харамгүй бэлэг өргөж, коммунистуудын сэтгэлийг хөдөлтөл бриллиантаар гар цайлгасныхаа дараа Зөвлөлтийн одонг ч хүртжээ. Сөрөг хүчнийхэн аймшигт харгислалд өртөж байв. Тусгай ангийн цэрэг байсан, каратэ сонирхдог тэр эсэргүүцлийн хөдөлгөөний удирдагчдыг шуудайд хийж дүүжлээд дасгал сургуулиа хийнэ. Онцгой заналт дайснуудынхаа махаар амтат зоог бэлдэхийг тушаана. Хөрөг зургийг нь хүндэтгээгүй гэсэн шалтгаар бага сургуулийн нэг ангийн бүх сурагчдыг тэр ачааны машин биечлэн жолоодож, дайрч алжээ.

Түүний даварсан байдалд эгдүүцсэн Франц улс сөрөг хүчний шударга тэмцлийг дэмжих нэрийн дор 3 рот десантчин илгээж, Бокассаг огцруулжээ. Францын иргэнийх нь хувьд түүнийг шүүх бүрэн эрхтэй ч тэгсэнгүй. Түүнд улс төрийн орогнол олгоно гэсэн Котдивуар улсад хүргэж өгчээ. Тэнд Бокасса дорхиноо уйдаж, удалгүй Францад очиж жаргасан төдийгүй, нэгэн хотынх нь хүндэт иргэн болжээ.

ҮЙЛБЕР БАЙБИ

Чулуун замнал

Мак Маклафлин чулуутай ажилладаг учраас тэвчээртэй хүн. Энэ чанар нь ч бизнест нь тус болно. Индиана штатын Эллетсвилл дэх Байби стоун компанийг хамтран эзэмшдэг. Аварга дугуй хөрөө шохойн чулууны 15 тн блокийг хэрхэн зүсч бэлтгэхийг тэрбээр харж зогсоно. Залуус аа, өнөөдөр амжуулах ёстой шүү гэж хашгична. Зүсэх машин хүржигнэж түржигнэн, ус савируулсаар нэг блок дээр 3 цаг зүтгэжээ. Нүсэр диск чих дөжрөм хяхтнаж, улам ч эрчтэй эргэлдэвч чулуунд 60 см л шигдсэн ажээ. Халуун наранд усан хулгана болсон, ядарч зүдэрсэн ажилчдыг харахад ямар тамын ажил болох нь тодорхой. Байбийн зүссэн блок оур цаанаа эзэнтэй. Нэг нь Дундад Барууны штатын хууль тогтоох хурлын барилга руу, нөгөө нь Нью Ёркийн тэнгэр баганадсан цамраг руу гэхчилэн илгээгдэнэ.

38 жил чулуутай ноцолдсон Макийн хувьд өнөөдөр л оддын цаг айсуу аж. Сүүлийн жилд 1990 оныхоос гантигийг 8 дахин, боржинг 20 дахин ихээр хэрэглэх болжээ. Шохойн чулууг их төлөв гэр бүлийн жижиг фирмүүд бэлтгэдэг болохоор тоо хэмжээг нь гаргахад түвэгтэй. Гэхдээ хэрэглээ нь хурдацтай өсч буй.

Урьд нь, шүүх банк зэргийн цөөн барилгыг сүрлэг, итгэл төрүүлэхүйц болгох гэж л чулууг ашигладаг байсан. 90-ээд оноос чулуу орчин үеийн стилийн бэлгэдэл болж хувирсан юм. Филип Жонсон, Майкл Грейвс нарын архитекторуудын санал болгосон сонгомол маягийн фасад, вестибюль моодонд орсноос тэр. Чулууны тусгаарлах чадварыг ч ойшооцгоосон билээ. Мөн хуучин барилгуудыг нураахын оронд сэргээн засварлах боллоо.

Эрэлт өсөхөд фирмүүд тоног төхөөрөмжөө шинэчилж, 2, 3 дугаар ээлжээр ажиллаж, тэтгэвэрт гарагсдыг эргүүлж дуудав. Индианагийн Монро, Лоуренс тойргууд сэргэн мандлаа. Энд ялимгүй гүнд 80 км урт, 6 хүртэл км өргөн, 20 м зузаан шохойн чулууны давхарга оршдог. Тиймээс түүхий эдийн талаар огтхон ч санаа зоволтгүй. Харин ч чулууг зарах тусам, ХАА-н эдлэн газрууд ихэснэ, сайжирна.

300-350 сая жилийн өмнө Индиана штат тэнгисийн ёроол байжээ. Шохойлгийг үүсгэгч организмын үлдэгдэл чулуун давхарга болж хувирсан. Америкийн хамгийн том чулууны ордууд энд буй. Эмпаер стейтбилдинг, Рокфеллер төв, Нью Ёркийн Метрополитен урлагийн музей, Коннектикут дэх Елийн их сургууль, 14 штатын парламент, Пентагон, вашингтоны засгийн газрын орднууд гээд олон алдартай байгууллага Индиана дахь Сейлемийн ил ордын нарийн ширхэгт чулуугаар чимэгдсэн.

Индиана штат тэр аяараа чулуу юм. Малын хашаа хороо, амбаар сав, худгийн хашлага, гарааш, гудамж талбай, барилга байшин бүгдийг чулуугаар барьсан байдаг. Чулуу өнгөн давхаргаас холгүй тул энд мод бут ч ургадаггүй, тариалан эрхлэх боломжгүй. Бэлчээрийн МАА, чулуу бэлтгэл л зонхилно. Индианагийн хүн бүр чулуутай ажиллаж чаддаг. Чулуучид үе удам дамжин энэүйлийг эрхэлдэг.

Үилбер Байби компанидаа 4 хүүгийн хамт зүтгэнэ. Ажилтнуудын олонх нь гурван шүээрээ хамт хөдөлмөрлөдөг. Тиймээс гэр бүлийн найрсаг сайхан уур амьсгал зонхилно. Ер нь чулуучид тайван, сэтгэлийн тэнхээтэй, ноён нуруутай, хатуужилтай хүмүүс байдаг. Чулуутайгаа адил болоо юу гэлтэй. Энэ нутгийнхан хамгийн арвин баялгаа ашиглахгүйгээр аж төрнө гэдгийг төсөөлөхгүй тул чулуучин болж, хүнд хэцүү хөдөлмөрийг сонгодог. Үүний ач буянд ч сайн сайхан аж төрдөг. Үилбер:

-Чулууг ойлгохын тулд түүнд амьдралаа зориулах хэрэгтэй. Тэгсэн цагт л чулуутай ажиллаж чадна. Миний мэдэх бүх өвөгдээдэс маань энэ ажлыг хийж байсан.

Орчин үеийнхэн чулуунаас нүүр буруулах болж. Энэ нь сайн зүйлд хүргэхгүй. Хэрэв та индианагийн шохойн чулуугаар байшингаа баривал зуу зуун жил бат бөх, намбалаг >.. йхан хэвээр байх болно. Бетон 10 жилийн дараа харахын эцэсгүй болдог. Чулуу бол цаг улирах тусам өнгө зүс засдаг. Гэхдээ элсэн чулуутийм ч онц биш хэмээн эндхийн аялаг дуудлагаар хүүрнэнэ.

Вашингтоны Капитолий элсэн чулуугаар баригдсан. Түүнийг шохойн чулуугаар солих шийдвэр гарсан нь Байби стоунид тааламжтай хэрэг болсон юм. Дашрамд, Үилбер бусад барилгын элсэн чулууг ч солихын төлөө хөөрхөн кампанит ажил өрнүүлж байгаа. Стандартын дөрвөлжин хавтан хэлбэртэй нарийн чулууг барилгын гадна талын өнгөлгөөнд ашиглана. Зузаан чулууг элдэв чммэг сийлбэрлэхэд зориулдаг. Компаний ачааллын 1/3 сэргээн засварлахад оногдоно. Эндхийн ажлын нөхцөл тэсвэрлэшгүй. Шохойн тоос бүхнийг хучиж, манан татуулна. Нүргээн, чахраан, исгэрээн, нүдээн бүгд нийлээд чих дөжрөм чимээ шуугиан. Хэн ч дуулга, чихэвч, комбинезонгүй байх нь гайхалтай. Зөвхөн шорттой зүтгэцгээнэ.

Тэнд ч нэг эр вашингтоны барилгад багана болох чулуунд гурив гаргахаар хичээнгүйлнэ. Энд ч нэг нь аркийн захыг бүрэх лөрвөлжин хэсгүүд хөрөөдөж, зүлгэнэ. Сийлбэрчин Аёва штатын шүүхэд зориулж чулуун навч мөчир урлана. Түүний өмнө байгаа фотонд элэгдэж мөлийсөн хуучин чимэг харагдана.

Чулуу моодонд орохоос өмнө сийлбэр хийх нь мөхөж буй мэргэжилд тооцогдон байсан. Гэтэл одоо ирээдүйтэй, нэр хүндтэй ажил гэгджээ. Суралцаж буй залуус цөөнгүй үзэгдэх нь үүнийг гэрчилнэ. Пневматик хуггаар тэд бяслаг зүсэх адил хөнгөн ажиллах нь урамтай.

Индианагийн сийлбэрчид Америктаа хамгийн уран. Цэиэгтэй ваар, сигар зуусан мэлхий зэрэг нарийн дүрслэл штатад хаа сайгүй тохиолдоно. Тэтгэвэрт гарсан сийлээчид булшнахаа хөшөөг урлан өрсөлддөг. Монро, Лоуренс тойргийн оршуулгын газрууд гайхамшигтай. Эцсийн уран бүтээлийн музей гэмээр.

Байбийн Рид карьерт очицгооё. Хөл бөмбөгийн талбай 20 м гүнл унасан мэт талбарт олборлол хийгдэнэ. 8 өндөр багана жоорондоо ган холбоосоор нэгджээ. Холбоосонд канатан хөрөөг бэхлэнэ. Нэлээн боловсронгуй эд тул хүн хүч нэн бага шаардана. Өнөөдөр 2 ажилчин нэг канатан хөрөөгөөр амжуулж буйг урьд 48 ажмлчин, 24 хөрөөдөгч машин хийх асан.

30 метр урт, таваарын вагон шиг хэлбэртэй блокуудыг дээр татаж гаргаад ахин хөрөөднө. Гологдол блок маш их гардаг. Өнгө цэвэр бус, ан цавтай, завсар нь шавар, элс, бусад элемент орсон гээд. Арвын нэг нь л стандарт блок болдог. Тиймээс Сейлемийн ордын хаанаас нь ч ухаж болдоггүй. Ордын доторхи орд гэж бас байна. Тэдгээрээс үүссэн хэдэн мянган нүхэнд ус тогтсон нь аймшигтай харагдана. Эрэггүй, байгальгүй, дөв дөрвөлжин, амьгүй чулуун нуурууд.

Чулууны ажил аль ч утгаараа хүнд бизнес. Тоос уушгинд, доргион бөөрөнд, ачаалал зүрхэнд, чимээ мэдрэлд, биеийн хүчир хөдөлмөр үе мөчинд гээд л муугаар нөлөөлөхийг тоочивч баршгүй. Чих хатуурах, хараа муудах, элдэв гэмтэл авах нь хүн бүрд л тохиолдоно.

Гэвч индианачууд хамгийн энгийн ажил мэргэжил л гэж үзнэ. Энэ нутгийнхан олон үеэрээ чулуунд дасан зохицож, бараг нэг хэсэг нь болжээ. Хамгийн хатуу хүтүүг ч хүмүүс нугалж чаддагийн амьд жишээ ажээ.

БЕН БА ЖЕНИН

Хачирхалтай хамтын ажиллагаа

Карибын тэнгисийн Виргин хэмээгч бүлэг арлыг Дани улс эзэмшдэг байсан юм. 1917 онд АНУ арлуудыг 25 сая доллараар худалдаж авна гээд шахалт үзүүлэхэд европын жижиг орон зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүрчээ. Зарим даничууд эндээ үлдсэн агаад Бений гэр бүлийнхэн Америкийн иргэд болцгоожээ. Виргинд төрсөн Состенес ба Эрнандо Бен гээч ах дүү хоёрыг ирээдүйд аугаа гүрнийг донсолгох юм гэж хэн мэдлээ.

Техник сонирхдог тэд эхлээд Виргиндээ телефон утасны орчин үеийн тогтолцоо буй болгож хөөрхөн баяжжээ. Анхны капитал аа буй болгохдоо эцэг Клаус Бенедиктусын загас агнуурын завийг барьцаанд тавин, мөнгө зээлж авч байсан гэдэг.

Виргиний дараа Пуэрто Риког телефонжуулахаар дайрав. Өчүүхэн пүүстээ интернешнл телефон энд телеграф буюу ИТТ гэсэн тун сүртэй нэр өгчээ. Үүний учир нь хүмүүст АТТ мэтээр ойлгуулахад дөхөмтэй гэж тооцоолсон байв. Энэ хоёрын лого нь ч төстэй. АТТ бол АНУ-ын харилцаа холбоонд монопольчилсон том компани байлаа. Тэдний дэндүү гэнэн тооцоо зөвдсөн нь хачирхалтай. Үнэхээр ч албан тушаалтнууд, байгууллагууд АТТ гэж эндүүрэн зээл олгож, гэрээ байгуулж байв. Америктай сайн дураар нэгдсэн улс гэгддэг Пуэрто Рико бүхэлдээ Бен нарт утасны мөнгөө төлдөг болов. Энэ үеэс ах дүүс ТТГ-г хандаж, хамтын ажиллагааг санал болгожээ. ТТГ ч Пуэрто Рикогийн салан тусгаарлагчдын яриаг чагнах сонирхолтой байсан тул Бен нарыг төрөл бүрээр ивгээхээ амлав.

1921 онд Испаний нэгэн язгууртан Ривера тэдэнтэй танилцаж, эхорондоотэргүүний телефон системтэй болохыг хүсчээ. Удалгүй ИТТ-гийн салбар Компания телефоника де Эспанья хилийн чанадад буй болов. Ерөнхийлөгчөөр нь нөлөөтэй дээдэс болох Герцог Альбагсонгосон нь ердөө л авилгалын нэгхэлбэрбайв.

Холбооны Вестерн электрик концерны булхайг Америкийн сенатын комисс мөрдөж байсан 1923 онд ТТГ Бенүүдэд том тус хүргэжээ. ТТГ-аас өгсөн чухал мэдээлэлд тулгуурлан ИТТ 30 сая доллараар Вестерн электрикийн гадаад дахь салбаруудыг худалдан авч. Интернешнл стандарт электрик буюу ИСЭ нэрийн дор нэгтгэв.

Үүний дараа Нью-Йоркийн Брод стритэд Бен нар 33 давхар өндөр байшинг мөн худалдан авч, гоёмсог засч тохижуулан, ХIY Людовикийн үеийн байдлаар янзлан, англи үйлчлэгч, франц тогоочдоор дүүргэжээ. Энэ тансаг ордонд зочилж цэнгээгүй хүн үгүй. Форд, Рокфеллер, Морган, Ротшильд гээд л бүгд айлчилсан. Бенүүдийн холбоо хэлхээ ч өргөжсөөр, зээл, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагаа хөвөрсөөр.

Нэгэнтээ тэд тансаг өргөөндөө ХI Пий Папыг урив. Чингэхдээ гол офисынхоо хананд папын сийлмэл хөргийг хадаж, хамба ламтанд гоёмсог алтан телефон бэлэглэсэн зэрэг нь хүндэт зочны сэтгэлийг ихэд хөдөлгөв. Пий Пап Ватиканыг болон бурхны олон шавь нарыгаа телефонжуулах захиалгыг Бенд өгөв.

Дараа нь ИТТ Европ руу давшлаа. Германы цахилгаан техникийн Сименс трест өөдөөс нь халуухан угтав. Сименсийн сүүдэрт дарагдан байсан шведийн Эрикссон, германы АЭГ, голландын Филиппс пүүсүүдтэй эвсэл байгуулан Сименстэй үзэлцлээ. Германы трест арга буюу буулт хийж, найрамдлын гэрээ оайгуулснаар ИТТ-д Европын үүд хаалга нээгдэв. Бен нар одоо хэрэггүй болсон түншүүд рүүгээ довтолж гарахад хөөрхийсийг Сименс шоолон инээлээ. АЭГ-тэй хамтран байгуулсан Штандарт электрикал текнишен компани-гаа ИТТ үнээр зодон булааж авав. Филиппс охин пүүс Лоренцийгоо худалдаж байж салахын түүс боллоо.

Харин Эрикссоны хувьд бүр ч хүнд цохилтод өртөв. ИТТ-гийн туршуулууд Эрикссон Англид маш их хууль бус ажиллагаа явуулж байсныг илчилснээр Бен нар хуучин түншээ дарамталж эхэлжээ. Швед компаний захирал Ивар Крюгер амиа хорлосон бол ИТТ акцийнх нь ихэнхийг төсөр үнээр худалдан авчээ.

1933 онд эелдэг Бен гэгдэх Эрнандо зүрхний өвчнөөр нас барж, догшин Бен гэгдэх Состенест бүр ч ширүүн авирлах боломж нээгдэв. Тэр яаран сандран нацистуудтай хамтын ажиллагаа тогтоов. Гитлерийн хүлээж авсан америкийн үйлдвэр-худалдааны хамгийн анхны төлөөлөгчид гэвэл Бен байв. Мань эрийг фюрер Герман-Америкийн бизнесийн хамтын ажиллагаанд зуучлах нэгэн гол хүн болгожээ.

Тэрбээр рейхийн эрчимтэй ажиллаж байсан аж үйлдвэрээс асар их ашиг олсон юм. Цэргийн том гэмт хэрэгтэн, СС-ийн штабын гишүүн Күрт Шрёдерийг өөрийн зөвлөхөөр томилсон хэмээж, цалин нэртэй хахуулиар татан, цаадах нь ч ИТТ-д ашигтай үйл олныг бүтээж өгчээ. Түүний ачаар Бен бөмбөгдөгч онгоцны Фокке Вульф заводын акцийн гуравны нэгийг эзэмшсэн билээ. Нэг хэсэг ИТТ хамаг гадаад хөрөнгө оруулалтаа Герман руу чиглүүлж байв.

Дэлхийн II дайны дараа Шрёдер Нюрнбергийн шүүхэд Бений нэрийг сэвтүүлэх юм огт хэлсэнгүй. Учир нь дуугүй байвал том харж үзнэ гэж түүнд амлажээ. Өөр нэг нацист түнш Герхард Вестрикийгээ сонин байдлаар аврав. Армийнхныг хахуульдсанаар Вестрик АНУ-ын цэргийн албан хаагч болж хувирчээ. Вестрик болон түүний дүү, хожим Эрхардын засгийн газрын сайд болсон Гюнтер нар ИТТ-г Баруун Германд хөлөө олоход нь мөн ч их тусалжээ.

ТТГ ч гар хумхин суусангүй. Германыг тагнаж чагнахад нь Состенес харамгүй зүтгэж байсан гэнэ. Ингээд нацистуудтай найзалж байсан тухай хамаг баримт нь ТТГ-ын ид шидээр алга болжээ. Дайны дараа Бен зүрхний удамшилт өвчинд дарлуулж, арга буюу үйл ажиллагаагаа сулруулав. Түүнийг орлочих хүн олдохгүй байсаар, 1956 онд ИТТ америкийн том компаниуд дотор 52-р байрыг эзэлжээ. Үхсэнээс нь хойш эзэнт улс нь нурж унахыг Бен хүссэнгүй.

Залгамжлагч захирлын авьяастан хайгчид урт удаан эрлийн эцэст, еврей гаралтай нягтлан бодогч Харольд Женинийг санал болгожээ. Түүнтэй ярилцаж үзээд л Бен өмнө нь хэн байгааг ойлгов. Бизнесийн суутан Женинийг хэн ч ойлгодоггүй, хүлээж авдаггүй байсан атал Бен шууд л ерөнхий захирал болгожээ. Удалгүй Состенес нас барсан аж.

Женин ИТТ-д шууд л дарангуйлал тогтоов. Гадаадаас ашгийн ихэнхийг олдог байсныг өөрчилж, капиталгаа Америкт төвлөрүүлэх нь ашигтай гэж үзэв. Гэхдээ 100 гаруй оронд таран ажилладаг үйлдвэрүүдээ ч худалдсангүй. Гагцхүү тэдэнд оруулдаг хөрөнгө оруулалтаа л хязгаартай болгожээ.

Америкийн доголдож эхэлсэн том пүүсүүдийг уулгамч юм шиг худалдан авч, сэхээн амилуулж байв. Нэг айлын орон сууц үйлдвэрлэх Левитт компани, зочид буудлын Шератон сүлжээ, Эй Би Си телевиз, шил шавраар эдлэл хийдэг трест, талх барих газар, автомашины прокат, даатгалын нийгэмлэг, чийдэнгийн завод, усан шахуургын фабрик, авто зогсоолууд гээд л бүхнийг худалдан авч, ИТТ-гийн хуримтлалыг дор нь үгүй хийв. Өрс дөгчид нь Женинийг галзуурсан гэж тооцож байлаа.

Гэвч тэр үнэхээр суут чадвартан байв. Түүнийг ИТТ-д ирэхэд жилийн хөрөнгийн эргэлт нь 761 сая доллар, рейтинг нь 52-рт байв. 10 жилийн дараа эргэлт 9 тэрбум, рейтинг нь Женерал Моторз, Стандард ойл, Форд, Женерал электрикийн дараа 5 дугаар байрт оржээ.

Жениний амжилтын нууц гэвэл Бений үр дүнтэй арга барилууд дээр өөрийн тооцоолох чадварыг нэмсэн явдал гэнэ. Үнэндээ тэр Америкийн хамгийн их тоо боддог захирал

бөгөөд дэргэдээ чадалтай математикч, нягтлан бодогчдоос бүрдсэн тооцоолох төв ажиллуулна.

Далаад онд Л атин Америкийн орнууд ээлж дараалан ИТТ- г эсэргүүцэв. Женин Аргентин, Бразил, Перуд салбаруудаа дамлан хуададаж дөнгөлөө. Харин Куба сохор зоос ч өгөлгүй үйлдвэрүүдийг нь булаачихжээ. Гэвч ИТТ тэндээс үйл ажиллагаагаа бүрмөсөн шлжүүлж, зөвхөн балгас л үлдээж амжсан байв. Гэтэл Чилийн коммунист Альенде нар асуудал учрууллаа. Энд мөнгө хаях нь зөв гэж үзсэн Женин Альендегийн эсрэг эргэлт зохион байгуулахад идэвхтэй оролцов. Альенде чунаж, Пиночет Женинийг Чилийн анд нөхөр хэмээснээр асуудал арилсан юм. Иймэрхүү улс төржсөн адал явдал бол Бений л хийдэг ажил билээ. Харин Женин тархинд нь Бен амилсан мэт л ажиллах болжээ.

Хамгийн гол нь тэр ИТТ-гийн акцийн ихэнхийг өөрийн болгож чадсан ажээ.

СИЛЬВИО БЕРЛУСКОНИ

Миланы наймаалж

Милан хотод 1936 онд Сильвио хүү банкны албан хаагч л үижигийн гэр бүлд төржээ. Гэхдээ түүний аав баян хүн байсангүй. Жирийн л нэг тоологч, бүртгэгч байв. Харин мөнгөний тухай, эздийнх нь тухай ихийг мэддэг нэгэн. Гэртээ ирээд баячуудын тансаг амьдрал, жаргал цэнгэлийн тухай мөрөөдөнгүй өгүүлнэ, Сильвиогийн ээж ч амтархан сонсч, бусад гэрий эзэгтэй нарт ярих санаатай, цээжлээд авахыг хичээнэ.

Сильвиод өөр амьдрал, сайхан ертөнц байдаг юм байна гэсэн ойлголт хар багаас нь бүрэлджээ. Бас дээрээс нь эцэг би ч яахав өнгөрсөн хүн, чи л олигтой амьдрах хэрэгтэй гэж байнга үглэхийг яана. Ямар ч гэсэн онцгой байх ёстой, гайхамшигт хүрэх учиртай гэх тэмүүлэл хүүд төлөвшжээ.

Аав нь түүнтэй банкчид болж тоглодог байсныг ч хэлэх үү. Балчир наснаасаа л мөнгө төгрөг хожиж сурав. Хүүхдийн хэд хэдэн тоглоомонд сайн байсан тэр хамт наадах гэсэн болгонд ямагт л хожвол төдөн лир авна гэсэн болзол тулгана. Үнэндээ мөнгө түүний хамгийн дуртай тоглоом байв. Үеийн нөхөд нь мөхөөлдөс авдаг атал тэрхуримтлуулсан зоосны гялбаандбаясна. Цэцэрлэгийн насандаа л мөнгө хүүлэгч болж хувирчээ. Сургуульд хичээнгүй, буурьтай зангаараа эрдмүүдийг түвэггүй эзэмшив. Ангийнхаа хүүхдүүдэд хуулуулах нь "бизнесийн" хөөрхөн эх суваг болохыг мэдээд гайхав. Яагаад нөхөд нь хичээлээ анхаардаггүй атлаа сүүлд нь Сильвиод мөнгө төлнө вэ?

1943 онд холбоотнууд Италийг эзэлж, фашист Мүссолиний дарангуйллыг унагалаа. Америкчууд харь гаригийнхан шиг л санагдав. Бүх юм нь шинэлэг, чамин, зөв зүйтэй мэт. Америкийн бүхэн моодонд орлоо. Балчир хүү Сильвио комиксийн ном олж аваад, түүнийг унших гэж англи хэлийг махран судлав. Нөхөддөө үзүүлж, орчуулж өгч шан хүртэнэ. Удалгүй Сильвио америк цэргүүдэд бяцхан тус хүргэж, урамшилд нь чамин зүйлс авч амташлаа. Түүнийгээ дамлаад зогсолгүй, бусад хүүхдүүдийн заруулах гэж өгсөн юмсыг өндөр үнээр борлуулна.

Өсч томрох тусмаа бизнес гэдэг амархан агаад дэндүү сонирхолтой юм гэж бодох болов. Бушуу насанд хүрч, компани байгуулах эрхтэй болохсон гэж мөрөөднө. Гэвч аав ээж нь их сургуульд сурахыг шаардав. Гэр бүлсэг итали зангаараа даган зөвшөөрөхөд хүрлээ. Их сургуулийн санхүүгийн ангийг сонгосон нь мэдээж. Оюутан байхдаа баян нөхдөөрөө зээл бүтээлгэж, эцэг эхээсээ нууцаар компани байгуулав. Тэр нь зуучлах үйл эрхэлнэ гэгдсэн ч хэзээ ч, юуг ч зуучилсангүй. Хамагл хууль дүрмийг зөрчиж, мөнгө олж болох бүхэнд хуруу дүрж, дураараа дургисан компани байлаа.

Гэхдээ сурлага сайтай оюутан байсныг нь мартаж болохгүй. Рекламын бизнесийн хуульзүйн асуудлуудаар дипломоо хамгаалж, оюутны шилдэг ажлын шагнал хүртэн төгсөв. Эцгийнх нь танил түүний мөрийг алгалан, банканд кассчиний ажил олж өгнө гэж амлалаа. Сильвио "Тэр кассчиний сандалд чинь өмд элэгдчихнэ. Харин би таныг аятайхан ажилд оруулж дөнгөх байх шүү" гэж даажигнаад зугтжээ. Аав нь ахмад хүнийг доромжлов гэж хилэгнэн зэмлэх гээд хүүгийнхээ ширээн дээр тавьсан

компаний ажил хэргийн хавтсыг хараад алмайрчээ. Төдөлгүй хүүдээ үйл ажиллагааны бүрэн эрх чөлөөг олгож буйгаа мэдэгдлээ.

1963 онд Сильвио Берлүскони сайн муу бүхий л аргыг хэрэглэн байж, Миланы маш ирээдүйтэй хойдхэсэгт ихэмжээний газар худалдан авч чадлаа. Милан бол Италийн бизнесийн төв, баячууд олонтой газар. Тиймээс энд газар алтны орд "-чг л үнэтэй. Хэрхэн Берлүскони үүнийг худалдан авсан бол. Түүнд шардлагатай мөнгөний 5 хувь нь ч байгаагүй гэдэг. Үнэндээ бол Сильвио эвслийн засгийн газарт гишүүд оруулсан нэгэн улс төрийн хүчний бульхайг сайтар судалж, шантаж хийжээ. Уг нам Миланд нөлөөтэй байлаа. Тиймээс, эсвэл фактуудыг гаргаж;тавина, эсвэл намд их хэмжээний хандив өгнө, гагцхүү уг газрыг миний халаасанд хий гэж шаарджээ. Намынхан Берлүсконид газар худалдсан гэсэн авч, төсөвт мөнгө ороогүй байв.

Удалгүй Сильвио Милан 2 нэртэй тансаг хороолол бариуллаа. Үүний санхүүжилт бас л бизнес-улс төрийн хуйвалдаанаас үүсэлтэй. Шинэ хороолол руу баян чинээлэгчүүд уулгалан дайрч, байруудыг дор нь худалдаж авлаа. Дахиад л нэг иймийг барьж өгөөрэй дээ гэж орж чадаагүйчүүд хүслээ. Мөнгөө бүр урьдчилан төлжээ. Бүр ч орчин үеийн, дээд зэргийн тохилог Милан 3 хороолол сүндэрлэлээ. Үүний дараа бүх миланчуудыг байлдан дагуулах Наранцэцэг хэмээх супер үйлчилгээний төвийг бүтээн босголоо. Төв хичнээн их амжилт олсныг Берлүскони сүлд тэмдгээ наранцэцэг болгосон нь нотолно.

Барилгын бизнес удалгүй түүнийг залхааж, уг салбарынхаа захирлаар нэгэн ухаант ажилтнаа томилж орхиод мэдээллийн зүг жолоо заллаа. Тэр хэдийнээс мэдээлэл сайтай явдаг, мэдээллийг бизнесийн нэг гол хүчин зүйл гэж үздэг, өндөр үнэлдэг байв. Нэр хүндтэй сонин Журналег мөнгөөр зодон байж авлаа. Мөн ТВ5 хэмээх телесувгийг буй болголоо. Өөр хэд хэдэн сувагтай болсноор улсын хүчирхэг телерадио компани РАИ-тай өрсөлдөв. Хэвлэлийн групп Мондадориг чадал заан байж өөрийн болголоо. Медиа салбар түүнд давхар давхар ашиг авчрав. Юуны өмнө үйл ажиллагааных нь шууд орлого. Хоёрдугаарт, сэтгүүлчдийн армия ашиглаж, чухаг мэдээлэл олж авч байв. Гуравдугаарт, өөрийгөө сайн сайхнаар рекламдаж чадав. Италичууд түүнийг Кавальере гэж нэрлэлээ.

1986 онд тэр 50 хүрлээ. Насны ойн шилдэг бэлэг нь, өөрөөс нь 17 дүү, үзэсгэлэнт жүжигчин Вероника Ларио байлаа. Улс орон даяар супер гэрлэлтийн тухай шуугиж байхад Кавальере спортын салбар луу хэлбийх тухай бодож байлаа. Эхний алхам болгож хөл бөмбөгийн Милан клубыг эзэмшив. Гүллит, Ван Бастен зэрэг голландчуудыг үнэ хаялцан байж ирүүлснээр Милан баг сэргэн мандлаа. Ийнхүү спортод амжилт олохын зэрэгцээ эстрад руу ухасхийв. Пипо Баудо, Раффаэла Карра гээд л оддыг худалдан авч гарав. Сильвиогийн сонирхохгүй юм гэж үгүй бололтой. Италийн бизнесийн өөр нэг аварга мангас Оливеттигийн Карло де Бенедетти бас тийм элдэв янзын юм сонирхдог хүн бөгөөд түүнтэй ноцтой өрсөлдөж эхлэв. Гэвч тэмцэлд мэдээж манай хүн ялсан.

Сильвио бол италийн олон талт үйл ажиллагаатай хамгийн том бизнесмен төдийгүй, хамгийн заль мэхтэй нь юм. Санхүүгийн операци явуулдаг Фининвест групп байгуулсан нь эхний жилдээ 11600тэрбум лир оллоо. Фининвест гэхдээ орлогоосоо 13дахин илүү өртэй ажиллаж байсан гэнэ. Хэвлэлүүдэд түүнийг огт сайн бизнесмен биш, харин ч бүтэлгүй нэгэн, тэр зөвхөн өр л хуримтлуулсан гэж бичих боллоо. Улс төртэй хугалдсан түүний зарим зээлийг засгийн газар баталгаажуулсан байжээ. Удалгүй Берлүскони сүйрнэ гэж ёрлоцгооно.

Италид эдийн засгийн хямрал ужгирч, ард түмэн авилгалд идэгдсэн төрийнхнөөс залхаж гүйцсэн байлаа. Нэг зальхай сайд огцроход нөгөө балмад этгээд суудалд нь залрана. Цөхөрсөн сонгогчид зүүний хүчин, коммунистууд рүү хэлбийж эхлэв. Тэд засгийн эрхэнд гарвал улс орон социалист туршлагын золиос болж, бүр ч дампуурах байлаа.

Гуравдахь хүч гарцаагүй хэрэгтэй байлаа. Тэр нь Кавальере болов. Мань хүн "Итали, урагшаа!" гэдэг нам байгуулж, дор нь хөл дээр нь зогсоов. Намын хөтөлбөр нь түвэгтэй биш агаад, бүхнийг зөв зүйтэй хийх явдал гэнэ. Сурталчилгаа нь ч, бохь, маёнезийнхтэй адил байлаа. Сильвиогийн уран илтгэгчийн авьяас тодров. Тэр түүнд таалагдаж эхэллээ. Аж ахуйчдад төрийн нөлөөг багасгах, ажилчин албан хаагчдад

ажилгүйдлийг хязгаарлах, ахмадуудад тэтгэвэр нэмэгдүүлэх, орлоготнуудад татвар бууруулахыг амлалаа.

Өөрийгөө бүтээсэн хүн буюу селфмэйдменд олон нийт итгэлээ. Тэр улс орныг ч өөд татаж чадна гэлцлээ. Ийм баян хүн авилгалд өртөхгүй ч хэмээв. Эмэгтэйчүүд түүнийг сайхан эрд тооцож, сонгогчдынх нь олонх болсон нь гайхалтай. Харин зарим эрчүүд сурталчилгаанд оролцсон Вероникагийн үгийг дагасан нь мэдээж. Барууны хүч өрсөлдөгч зүүнтнүүдийг бут цохихын тулд Берлүсконид тусалж байв. Уг нь тэд "Итали, урагшаа!"-г амжилт олохгүй гэж таамагласан бололтой.

Гэвч сонгуулийн дүнд Сильвиогийн нам 40 хувийн санал авчээ. Мань хүн ерөнхий сайд болно гэсэн дэндүү дэвэргэн хүслээ биелүүлэв. Улс орон түүний гарт орлоо. Албан тушаалаа бараг хаан суудал болгож дөнгөв. Амлалтынхаа заримыг биелүүлсэн ч бүгдийг бус. Харин төрийн албан хаагчдын шамшигдуулал, авилгалыг багасгана гэдгийгээ 70-80 хувьтай биелүүлсэн нь том амжилт юм.

Дараагийн сонгуульд Берлүскони бут цохиулсан. Ерөнхий сайд байхдаа мань хүн хэтэрхий их хэл аманд өртжээ. Тэр нь ч аргагүй. Бусдын завшилтыг эрс бууруулсан ч, "хэмнэсэн" зүйлээ тэрбээр бүгдийг нь халаасалж байжээ. Айхавтар их өр нь ч ор мөргүй болсон нь ойлгомжтой. Италид улсын сектор хүчтэй байдаг. Хүчийг нь бууруулах талаар Кавальере багагүй анхаарч, цөөнгүй мундаг объектыг хувьчилж авсан. Энэ бүхнийхээ талаар шуугиулаад авсан хүн чинь яаж ч сонгогдох вэ дээ. Ял шийтгэл сонсоогүйгээ л их юм гэж бодох үлдсэн.

Гэтэл Сильвиогийн дараа гарч ирсэн этгээдүүд ард түмэнд бүр ч таалагдаагүй. Хэсэг хугацааны дараа Берлүскони ахин ерөнхий сайд болсон юм. Тийм ээ, өнөөдөр тэр Италийн ерөнхий сайд билээ. Гэхдээ бас л завшилга, хахуулийн хэрэгт холбогджээ. Гишүүн улсуудын тэргүүн нар ээлжлэн Европын холбоог удирддаг. Харин Европарламентынхан Сильвиогийн ээлж ирэхэд хүлээн авахаас эрс татгалзаж, ширүүн эсэргүүцэл үзүүлжээ.